



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 1/48

Ховд

Төрийн архивын тасгийг нүүлгэн шилжүүлэхэд  
ажиллах бүрэлдэхүүнийг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/07 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Архивын аюулгүй ажиллагааны журам”-ын 6.1-6.2.12 дахь заалтууд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/204 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 6.20.1, 6.21 дэх заалт, Архивын баримтыг ачих, буулгах үеийн аюулгүй ажиллагаанд MNS5079:2001 стандартыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийг нүүлгэн шилжүүлэхэд ажиллах бүрэлдэхүүнийг томилсугай.

Дарга: Н.Ганзориг (Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Гишүүд: Б.Энхмандал (Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн нягтлан бодогч)

Х.Болормаа (Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн нярав)

Ц.Лувсанлхамо (Нийтлэг үйлчилгээний тасгийн дарга)


Төрийн архивын тасгийн ажилтнууд

Д.Энхзоригт (Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга)

Нарийн бичгийн дарга: Ч.Эрдэнэбат (Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

2. Тасгийг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний дагуу сайтар зохион байгуулахыг комиссын дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА



Б.САНДАГСҮРЭН

14 77773 0239  
Tush A/48 Ba